

**“ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ  
ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 04 дүгээр  
сарын 18-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 03 дугаар сарын 23, 24-ний өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамаар ахлуулж, гишүүдэд Д.Батлут, Н.Ганибал, Х.Ганхуяг, Б.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллалаа.

Ажлын хэсгээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн автомашинаас эмнэлгийн тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор алслагдмал сумдын Эрүүл мэндийн байгууллагад болон бусад төрийн байгуулагуудад шилжүүлэх, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгасантай холбогдуулан тухайн хөрөнгийг орон нутгийн өмчлөлд шилжүүлэх талаар зарчмын зөрүүтэй нийт 39 санал, найруулгын 2 саналыг тогтоолын төслийн хавсралтад нэмэх саналын томъёолол бэлтгэн Байнгын хорооны хуралдааны анхны хэлэлцүүлэгт оруулсан болно.

Байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут улсын онцгой объект болох Орхон аймгийн иргэдийн ундны цэвэр усны дэд станцуудын харуул хамгаалалтад дотоодын цэргийн ангийн ашиглаж байсан “Эрдэнэт” үйлдвэрийн эзэмшлийн автомашиныг Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хураан авсныг буцаан олгох асуудлыг шийдвэрлэх, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг орон нутгийн өмчид шилжүүлсэн автомашины засвар үйлчилгээний асуудалд анхаарах, эдгээр автомашинуудын хуваарилалтыг нээлттэй, ил тод болгох, Улсын Их Хурлын гишүүн О.Цогггэрэл Улсын Их Хурал төрийн өмчийн бодлогын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг байх, тавилга, эд хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх, хуваарилах асуудлыг Засгийн газар, агентлагийн түвшинд шийддэг байх гэсэн саналыг тус тус хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг Улсын Их Хурлаар хэлэлцэх ач холбогдол багатай эд хөрөнгө шилжүүлэх, хуваарилах талаар олон саналын томъёолол гарч байгаа тул Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.23 дахь хэсгийг үндэслэн тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Ц.ЦЭРЭНПУНЦАГ**